КРЕДИТ
ББСБ

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 он 02 сар 10 өдөр Дугаар 23/А/18 Улаанбаатар хот

Цахим үйлчилгээний ерөнхий
нөхцөл батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хамаарал бүхий компаниуд бүтээгдэхүүн үйлчилгээг Ард аппликейшнээр дамжуулан авах Цахим үйлчилгээний ерөнхий нөхцөлийг Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Систем шинжилгээний албаны менежер (А.Дуним)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан бодлогын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хуулийн зөвлөх (Б.Уранцэцэг), хяналт тавин ажиллахыг Дотоод аудитор (Б.Оюунгэрэл) нарт тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ТЭЛМЭН

АРД КРЕДИТ ББСБ ХК 1119281372 УЛААНБААТАР ХОТ

Гүйцэтгэх захирлын
2023 оны 02 сарын 20 өдрийн
23/A/19 тоот тушаалын Хавсралт№1

# ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү Цахим үйлчилгээний ерөнхий нөхцөл нь ("ЦҮЕН") Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний хамааралтай компаниуд ("АСН")-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг Ард Аппликейшн ("Ард Апп)-аар дамжуулан авахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.[1]

1.2. Энэхүү ЦҮЕН болон түүнд орох нэмэлт, өөрчлөлтийг www.ardholdings.com цахим хуудас болон Ард Аппад байршуулж мэдээлэл хүргэнэ.

1.3. Харилцагч цахим үйлчилгээ ашигласан нь АСН-ийн салбарт өөрийн биеэр ирж, бүтээгдэхүүн, үйлчилгээ авахтай адил тооцогдож, хүчин төгөлдөр байна.

1.4. Баталгаажуулалтын хэсэг дэх **"Цахим мөнгөний үйлчилгээний гэрээ"**-ний 8.2-т заасны дагуу тухайн гэрээнд гарын үсэг зурснаар энэхүү ЦҮЕН болон түүнд орох нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

1.5. АСН-ийн бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл, мөн холбогдох хууль журам зэрэгт өөрчлөлт орсонтой холбогдуулж ЦҮЕН-ийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд энэ талаарх мэдээллийг өөрийн www.ardholdings.com веб сайт эсвэл Ард Аппаар дамжуулан мөрдөгдөх хугацаанаас 3-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

1.6. ЦҮЕН-д орсон нэмэлт, өөрчлөлт оруулах талаар мэдээлэл хүргэснээс хойш 3 хоногийн хугацаанд харилцагчаас санал, хүсэлт ирүүлээгүй бол ЦҮЕН-д орсон нэмэлт, өөрчлөлтийг талууд хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр харилцан тохиролцов.

1.7. Энэхүү ЦҮЕН-ийн 1.5-д дурдсан мэдээллийг веб сайт болон Ард Аппаар мэдэгдэж байхыг харилцагч үүгээр зөвшөөрч буй бөгөөд ЦҮЕН-д оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт, шинэчлэлтийн дараа үйлчилгээг авч, үргэлжлүүлэн ашигласаар байгаа бол эдгээр нэмэлт өөрчлөлт, шинэчлэлтийг дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

## ХОЁР.ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ, ТҮҮНИЙ НӨХЦӨЛ

2.1. АСН нь өөрийн лавлах утас[2] болон цахим сүлжээ, платформ дахь албан ёсны баталгаажсан тэмдэг бүхий хуудас[3], цахим шуудангийн хаягаас[4] харилцагчтай харилцана.

2.2. Дараах тохиолдолд АСН нь харилцагчийн мэдээллийг шаардана. Үүнд:

| **Үйлчилгээний төрөл** | **Шаардах асуумж** | **Холбогдох хэлбэр** |
|---|---|---|

[1] Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний хамааралтай компаниудын Ард Аппад байршуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг цаашид **"цахим үйлчилгээ"** гэх

[2] 77003322

[3] ArdFinancialGroup

[4] help@ard.mn, burtgel@ardcredit.com

| | | |
|---|---|---|
| Зээлийн лавлагаа | Бүртгэлтэй дугаар, Овог, нэр, РД | Бүртгэлт холбогдо |
| Харилцах дансны хуулга | Бүртгэлтэй дугаар, Овог, нэр, РД | Бүртгэлт холбогдо |
| АрдКойн дансны хуулга | Бүртгэлтэй дугаар, Овог, нэр, РД | Бүртгэлт холбогдо |
| Хувьцааны лавлагаа | Бүртгэлтэй дугаар, Овог, нэр, РД | Бүртгэлт холбогдо |
| Пин код сэргээх | Бүртгэлтэй дугаар, Овог, нэр, РД | Бүртгэлт холбогдо |
| Борлуулалт | Найзаа урих код | Бүртгэлт холбогдо |
| Бүртгэлтэй дугаар солих | Бүртгэлтэй дугаар, Овог, нэр, РД, Тан код | Албан ёс чат болон шууданга солих өр хамт сел үнэмлэхи зураг |
| Зээл хаасан тодорхойлолт | Бүртгэлтэй цахим шуудангийн хаягаас хүсэлт явуулсан байх бөгөөд тухайн хаягт тодорхойлолтыг илгээнэ. | Албан ёс чат болон burtgel@ шууданга хүссэн өр өргөдөлт Иргэний |
| Зээлийн гэрээ цуцалсан тодорхойлолт | | |

2.3. ЦҮЕН-ийн 2.2-т зааснаас бусад тохиолдолд АСН хар болон нууц үг, бусад баталгаажуулалтын хэсгийн мэдээл аливаа мэдээллийг[5] шаардахгүй тул АСН-тэй ижил эсхү цахим орчимд АСН-ийг төлөөлж буй мэт дүр эсгэн ханд шинжтэй санал, хүсэлт, шаардлагад нууц мэдээллээ өгөх гарсан үр дагаврыг харилцагч өөрөө хариуцах ба энэ тала

2.4. АСН нь бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээлэл, нөхцөл, п зээлийн мэдээллийг зөвхөн АСН-ийн цахим сүлжээ, пла баталгаажсан тэмдэг бүхий хуудас болон АСН лавлах утс

2.5. Харилцагч өөрийн мэдээллийг нууцлан хамгаалах үүргэ болгоомжгүйгээс бусдад алдсан, дамжуулсны улмаас зал гүйлгээ хийгдсэний улмаас хохирол учирсан бол ца байгууллагад хандан шийдвэрлүүлэх ба АСН-ийн мэдээллийг гарган өгч хамтран ажиллана.

2.6. Ард Аппын нэвтрэх нэр, нууц үг, пин код, тан код мөн цахим шуудангийн хаяг, утасны дугаар, нууц ас

[5] "Ард Апп дахь аливаа мэдээлэл" гэдэгт дараах мэдээллүүд хамаарна. Үүнд:

1. Нэвтрэх нэр, нууц үг, тан код, найзаа урих код, утасны дугаар, цахим Апп дах бусад мэдээлэл